



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/92

Жаргалтхаан

Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 10 дугаар зүйлийн 10.2, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 70,000,000 (далан сая) төгрөгийн хөрөнгөөр хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засвар тохижилт" ажлын гэрээг "Шижир цагаан" ХХК-тай байгуулж санхүүжүүлэх эрх олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлийг харгалзан санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан батлуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232431219